



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТ

АУДИТЫН КОД: АХГ-2022/222/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжапгал
Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Нарангэрэл
Утас: 261628 Цахим хаяг: narangerelba@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	2
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	17
3.8.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
ЗГ	Засгийн газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УИХ	Улсын их хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Л.ДАШДЭМБЭРЭЛ
ТАНАА

2022.0325 № 01/723
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүгнэлтийн үндэслэлд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 391.8 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас харьяа байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,778.9 сая төгрөгийн 115 алдаа, зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, эрх ба үүрэг, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,353,721.1	2,543,483.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	39,473.4	42,861.6
33	АВЛАГА	910,330.9	820,706.3
34	УРЬДЧИЛГАА	9,019.2	13,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	1,394,897.7	1,666,915.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	45,756,024.9	44,205,084.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	45,756,024.9	44,205,084.3
39200	Биет хөрөнгө	39,896,711.3	38,881,423.7
39300	Биет бус хөрөнгө	5,859,313.6	5,323,660.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	48,109,746.0	46,748,567.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,632.7	19,746.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,632.7	19,746.6
41300	Өглөг	12,632.7	19,746.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	48,097,113.3	46,728,821.3
51	Засгийн газрын хувь оролцоо	48,097,113.3	46,728,821.3
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,585,763.3	14,585,763.3
51200	Хуримтлагдсан үр дүн	27,379,321.4	26,021,913.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,132,028.6	6,121,144.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	48,109,746.0	46,748,567.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	121,824,551.4	32,819,451.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,864,495.1	3,976,420.5
120	Нийтлэг татварын бус орлого	15,864,495.1	3,976,420.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	105,960,056.3	28,843,031.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	111,590,539.0	33,906,300.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	111,590,539.0	33,906,300.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,175,581.6	31,192,910.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,165,055.8	19,927,079.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,498,861.7	2,532,386.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,914,405.7	1,872,549.8
2104	Хангамж, бараа материалын зардал	1,047,105.2	858,007.8
2105	Норматив зардал	664,292.9	434,977.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	112,853.7	94,336.6
2107	Томилолт, зочны зардал	38,524.9	26,036.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,351,458.1	1,073,523.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,383,023.5	4,374,011.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,414,957.4	2,713,389.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	10,234,012.4	(1,086,848.2)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	39,155.7	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	807,945.6	349,265.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	9,465,222.5	(1,436,113.7)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,447,302.0	0.0	38,447,302.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	234,836.9	0.0	234,836.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,682,138.9	0.0	38,682,138.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(50,248.1)	0.0	(50,248.1)
9	Тайлант үеийн үр дүн	9,465,222.5	0.0	9,465,222.5
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,097,113.3	0.0	48,097,113.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	78,705.8	0.0	78,705.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,175,819.1	0.0	48,175,819.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(10,884.1)	0.0	(10,884.1)
19	Тайлант үеийн үр дүн	(1,436,113.7)	0.0	(1,436,113.7)
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	46,728,821.3	0.0	46,728,821.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	109,223,680.9	30,461,259.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,683,846.1	1,149,184.3
120	Нийтлэг татварын бус орлого	1,683,846.1	1,149,184.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	107,539,834.8	29,312,075.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	109,034,706.6	30,335,373.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	109,034,706.6	30,335,373.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,130,176.1	27,193,225.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,838,976.4	19,854,657.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,523,426.8	2,537,019.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,930,472.0	1,874,644.3
2104	Хангамж, бараа материалын зардал	875,329.0	812,815.8
2105	Норматив зардал	673,656.9	304,911.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	152,220.8	128,834.3
2107	Томилолт, зочны зардал	38,324.9	20,361.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,634,746.9	1,187,287.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	463,022.4	472,693.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,904,530.5	3,142,148.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	188,974.3	125,885.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	177,006.4	106,155.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	177,006.4	106,155.3
2200	Дотоод эх үүсвэрээр	177,006.4	106,155.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(177,006.4)	(106,155.3)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(3,317.2)	(16,342.2)
14	Бусад эх үүсвэр	151.5	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	3,468.7	16,342.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	8,650.6	3,388.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	30,822.8	39,473.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	39,473.4	42,861.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,959,591,500.00	26,860,683,278.73	2,098,908,221.27	92.8
УРСГАЛ ЗАРДАЛ	28,959,591,500.00	26,860,683,278.73	2,098,908,221.27	92.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,165,731,900.00	26,130,170,439.45	2,035,561,460.55	92.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,849,896,600.00	19,738,788,299.96	111,108,300.04	99.4
Үндсэн цалин	14,187,372,100.00	14,118,149,279.01	69,222,820.99	99.5
Нэмэгдэл	4,628,659,400.00	4,449,898,780.40	178,760,619.60	96.1
Унаа хоолны хөнгөлөлт	1,033,865,100.00	1,125,033,756.51	(91,168,656.51)	108.8
Урамшуулал	0	45,706,484.04	(45,706,484.04)	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,588,361,900.00	2,517,579,156.32	70,782,743.68	97.3
Тэтгэврийн даатгал	1,827,879,200.00	1,818,484,438.20	9,394,761.80	99.5
Тэтгэмжийн даатгал	189,807,600.00	180,331,021.42	9,476,578.58	95.0
ҮОМШӨ-ний даатгал	154,946,200.00	141,678,354.61	13,267,845.39	91.4
Ажилгүйдлийн даатгал	39,461,300.00	36,529,077.47	2,932,222.53	92.6
Эрүүл мэндийн даатгал	376,267,600.00	340,556,264.62	35,711,335.38	90.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,989,329,500.00	1,861,155,355.91	128,174,144.09	93.6
Гэрэл, цахилгаан	302,044,400.00	294,414,357.96	7,630,042.04	97.5
Түлш, халаалт	924,190,000.00	865,996,537.73	58,193,462.27	93.7
Цэвэр, бохир ус	151,560,900.00	119,418,531.06	32,142,368.94	78.8
Байрны түрээс	611,534,200.00	581,325,929.16	30,208,270.84	95.1
Хангамж, бараа материалын зардал	613,127,200.00	516,829,668.44	96,297,531.56	84.3
Бичиг хэрэг	124,546,600.00	118,141,143.56	6,405,456.44	94.9
Тээвэр, шатахуун	132,234,100.00	100,657,712.31	31,576,387.69	76.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	133,902,800.00	106,064,718.81	27,838,081.19	79.2
Ном, хэвлэл	1,888,600.00	46,892.20	1,841,707.80	2.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	24,775,900.00	18,193,768.00	6,582,132.00	73.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	195,779,200.00	173,725,433.56	22,053,766.44	88.7
Норматив зардал	831,148,600.00	285,808,832.15	545,339,767.85	34.4
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,983,500.00	6,922,060.00	12,061,440.00	36.5
Хоол, хүнс	758,854,600.00	251,569,875.45	507,284,724.55	33.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл	53,310,500.00	27,316,896.70	25,993,603.30	51.2
Эд хогшил, урсгал засварын зардал	243,772,200.00	181,741,658.00	62,030,542.00	74.6
Багаж, техник, хэрэгсэл	141,904,500.00	108,708,228.00	33,196,272.00	76.6
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,510,000.00	2,798,100.00	711,900.00	79.7
Урсгал засвар	98,357,700.00	70,235,330.00	28,122,370.00	71.4
Томилолт, зочны зардал	14,018,500.00	6,063,121.06	7,955,378.94	43.3
Дотоод албан томилолт	9,636,400.00	5,324,243.66	4,312,156.34	55.3
Зочин төлөөлөгч хүлээн авах	4,382,100.00	738,877.40	3,643,222.60	16.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,994,656,700.00	1,008,402,601.85	986,254,098.15	50.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,697,881,100.00	764,904,935.32	932,976,164.68	45.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	124,160,700.00	123,170,900.00	989,800.00	99.2
Даатгалын үйлчилгээ	83,610,100.00	56,115,811.90	27,494,288.10	67.1
Тээврийн хэрэгслийн татвар	11,845,500.00	8,158,260.00	3,687,240.00	68.9

Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,998,900.00	2,391,800.00	607,100.00	79.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,050,000.00	28,941,455.90	7,108,544.10	80.3
Газрын төлбөр	14,551,600.00	11,730,566.00	2,821,034.00	80.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,971,100.00	4,402,771.33	4,568,328.67	49.1
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	14,587,700.00	8,586,101.40	6,001,598.60	58.9
Бараа үйлчилгээний бусад зардал	41,420,700.00	13,801,745.76	27,618,954.24	33.3
Бараа үйлчилгээний бусад зардал	8,078,300.00	4,556,812.30	3,521,487.70	56.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,342,400.00	9,244,933.46	24,097,466.54	27.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	793,859,600.00	730,512,839.28	63,346,760.72	92.0
Бусад урсгал шилжүүлэг	793,859,600.00	730,512,839.28	63,346,760.72	92.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	752,452,500.00	689,349,597.28	63,102,902.72	91.6
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,407,100.00	41,163,242.00	243,858.00	99.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,959,591,500.00	26,877,997,798.93	2,081,593,701.07	92.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,868,322,700.00	26,343,465,638.11	524,857,061.89	98.0
Улсын төсвөөс санхүүжих	26,868,322,700.00	26,343,465,638.11	524,857,061.89	98.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,091,268,800.00	534,532,160.82	1,556,736,639.18	25.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	208,123,000.00	117,424,585.00	90,698,415.00	56.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,883,145,800.00	417,107,575.82	1,466,038,224.18	22.1
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,320	3,314	6	99.8
БАЙГУУЛЛАГЫН ТОО	34	34	0	100.0
Төсвийн байгууллага	34	34	0	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	1,643	1,640	3	99.8
Удирдах ажилтан	35	35	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	1,327	1,324	3	99.8
Үйлчлэх ажилтан	281	281	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Т3 цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,443,752,711.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,443,752,711.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,145,030,116.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		115,869,552.00
210101	Үндсэн цалин		115,144,689.00
210102	Нэмэгдэл		424,863.00
210104	Урамшуулал		300,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		19,440,260.01
210201	Тэтгэврийн даатгал		19,425,560.01
210202	Тэтгэмжийн даатгал		4,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		6,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал		600
210205	Эрүүл мэндийн даатгал		3,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		13,488,959.00
210301	Гэрэл, цахилгаан		3,006,183.00

210302	Түлш, халаалт		10,482,776.00
2104	Хангамж, бараа материалын зардал		296,890,881.15
210401	Бичиг хэрэг		147,678,800.00
210402	Тээвэр, шатахуун		66,684,596.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		45,396,992.65
210404	Ном, хэвлэл		2,305,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,595,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		33,229,892.50
2105	Норматив зардал		19,102,187.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		6,117,500.00
210502	Хоол, хүнс		12,984,687.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		22,200,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		11,600,000.00
210602	Тавилга		6,300,000.00
210604	Урсгал засвар		4,300,000.00
2107	Томилолт, зочны зардал		14,298,500.00
210702	Дотоод албан томилолт		14,298,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		201,319,757.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		173,626,757.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		27,693,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		442,420,020.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		410,463,520.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		31,956,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,298,722,594.76
2132	Бусад урсгал шилжүүлэг		836,906,854.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		825,795,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		3,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		8,111,304.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		461,815,740.76
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		15,794,221.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		438,821,519.76
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		7,200,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,443,752,711.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,443,752,711.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		840,854,318.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		680,744,017.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		388,879,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		533,275,376.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэлд орлогыг төрлөөр нь ангилан бүртгэх, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг цаг тухайд нь шилжүүлэхэд хяналт тавих, төсвийн хэмнэлтийн талаар гаргасан Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, батлагдсан төсвийг зохистой удирдаж, үр ашигтай зарцуулах, анхан шатны баримтын бүрдлийг хангах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хооронд ахлах аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/344 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн хүн амд оновчтой хүргэх, чанар, хүртээмж, үр ашгийг сайжруулах замаар иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад оршино.” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын уялдаа холбоог хангах, төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Иргэний хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын жишигт нийцүүлэн мэргэжлийн боловсрол, ур чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн харилцааны соёл төлөвшүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлж, ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох;
- Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хууль тогтоомж, бодлогын

хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлын түвшнийг бууруулах;

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээллийн нэгдсэн системийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, бодлогын загварчлал боловсруулах, салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг орчин үеийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулах, хөгжүүлэх.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төсөвлөлт, зарцуулалт, тайлагналтыг ил тод нээлттэй болгож, хяналтыг сайжруулах.
- Бодлогын хэрэгжилтийн явц, салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төлөвлөлт, гүйцэтгэл, үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай;”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хяналт мониторингийн газар нь 2021 онд ХХҮЕГ-ын болон харьяа аймаг, дүүргийн 6 газар, хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаа, Халамжийн сан, ХЭДС-ийн төсвийн зарцуулалтад хяналт шалгалт хийхээр төлөвлөж, Баянзүрх дүүргийн ХХҮГ, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Говь-Алтай, Дорнод аймгийн ХХҮГ-ын үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хийж, 79.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 92.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, нийт 175 зөвлөмж өгсөн байна. Үүнээс 16.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 92.4 сая төгрөгийн албан шаардлага, 165 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Жилийн ажлын төлөвлөгөөнд тусгасан ХЭДС-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавартай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 33,479.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 334.8 сая төгрөгөөр тооцсон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,631.2 сая төгрөгөөр буюу 4.1 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 42.8 сая төгрөг болж, өмнөх оноос 3.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	424.8	0.0	(424.8)
Төрийн сангийн харилцах	38,573.9	39,346.8	772.9
Арилжааны банкны үлдэгдэл	0.0	0.2	0.2
Гадаад валют	474.7	3,514.6	3,039.9
Дүн	39,473.4	42,861.6	3,388.2

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 39.3 сая төгрөг Төрийн сангийн харилцах дансанд, 0.2 сая төгрөг арилжааны банканд, валютын харилцах дансанд 3.5 сая төгрөг тус тус байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Дорнод аймгийн ХХҮГ нь ноос ноолуурын орлогын 33.6 сая төгрөгийг кассын тайланд орлого, зарлагаар тусгаагүй, цахилгааны төлбөрийг нэхэмжилсэн дүнгээс 0.6 сая төгрөгөөр илүү шилжүүлсэн;
- Бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхдээ 40.9 сая төгрөгийн төлбөрийн и-баримтыг бүрдүүлээгүй, Төв аймгийн ХХҮГ 24.2 сая, ХХҮЕГ 15.3 сая, Завхан аймгийн ХХҮГ 1.4 сая/
- ХХҮЕГ нь валютын харилцах дансны 3.5 сая төгрөгийн үлдэгдлийг касст байгаа бэлэн мөнгөөр тайлагнасан;
- Төв аймгийн ХХҮГ харилцах дансны 1.7 сая төгрөгийн орлогыг журналд бүртгээгүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 820.7 сая төгрөг болж, өмнөх оноос 89.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	11,340.5	9,640.3	(1,700.2)
Төлбөртэй үйлчилгээний авлага	4,077.8	165.0	(3,912.8)
Татаас, санхүүжилтийн авлага	460,331.9	420,310.6	(40,021.3)
Байгууллагаас авах авлага	144,475.1	132,014.4	(12,460.7)
Хувь хүмүүсээс авах авлага	290,105.6	258,576.0	(31,529.6)
Дүн	910,330.9	820,706.3	(89,624.6)

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл 89.6 сая төгрөгөөр буурсан нь БНСУ дахь хөдөлмөр, нийгмийн хамгааллын төв 34.5 сая, Нийслэлийн ХХҮГ 44.7 сая, Орхон аймгийн ХХҮГ 7.9 сая, Ховд аймгийн ХХҮГ 3.9 сая, Булган аймгийн ХХҮГ 1.2 сая төгрөгөөр буурсан нь шалтгаалсан байна.

Ажиллагсадтай холбоотой 9.6 сая төгрөгийн авлага Дорноговь аймгийн ХХҮГ, Булган аймгийн ХХҮГ, татаас санхүүжилтийн 420.3 сая төгрөгийн авлага Нийслэлийн ХХҮГ, Дорнод аймгийн ХХҮГ, байгууллагаас авах 132.0 сая төгрөгийн авлага, ХХҮЕГ, хувь хүмүүсээс авах 258.6 сая төгрөгийн авлага, БНСУ дахь ХНХҮТ, Орхон аймгийн ХХҮГ, Говь-Алтай ХХҮГ-т тус тус хамааралтай байна.

Аудитын илрүүлэлт:

- Говь-Алтай аймгийн ХХҮГ нь газар нөхөн олговрын 7.4 сая, татварын авлага 0.1 сая, Булган аймгийн ХХҮГ тайлант хугацааны 1.5 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;
- ХХҮЕГ нь 2010 онд үүссэн 7.7 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 13.0 сая төгрөг болж, өмнөх оноос 4.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	9,019.2	13,000.0	3,980.8
Дүн	9,019.2	13,000.0	3,980.8

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд Өмнөговь аймгийн ХХҮГ-ын 13.0 сая төгрөгийн худалдан авалтын төлбөр бүртгэлтэй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 1,666.9 сая төгрөг болж, өмнөх оноос 272.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	39,724.5	42,278.2	2,553.7
Эм боох материал	3,724.4	4,433.3	708.9
Бэлэн бүтээгдэхүүн	20,957.1	19,835.8	(1,121.3)
Бичиг хэргийн материал	91,260.8	101,162.4	9,901.6
Аж ахуйн материал	589,868.2	588,815.2	(1,053.0)
Сэлбэг хэрэгсэл	58,523.7	56,669.2	(1,854.5)
Түлш, шатах тослох материал	61,480.4	60,495.5	(984.9)
Барилгын засварын материал	7,657.0	7,720.3	63.3
Хүнсний материал	19,342.1	6,034.6	(13,307.5)
Бусад хангамжийн материал	481,377.4	745,906.2	264,528.8
Мал амьтад	20,982.0	33,565.0	12,583.0
Дүн	1,394,897.7	1,666,915.6	272,017.9

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал худалдан авалтаар 1,246.6 сая төгрөг, байгууллага хооронд болон үндсэн хөрөнгө данснаас бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэсэн 61.9 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 411.7 сая, дотоод гүйлгээгээр 20.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 1,369.0 сая төгрөг, шилжүүлсэн болон хоорондын тооцоогоор 45.5 сая төгрөг, дотоод гүйлгээгээр 53.8 сая төгрөгийн дүнгээр буурчээ.

Аудитын илрүүлэлт:

- ХХҮЕГ-ын агуулахад ашиглах боломжгүй болсон 6 нэр төрлийн 74.1 сая төгрөгийн гарын авлага, тараах материалын үлдэгдэлтэй, Нийгмийн халамжийн сангийн хөрөнгөөр худалдаж авсан 149.0 сая төгрөгийн брошур, плакатаас тайлант онд 59.6 сая төгрөгийн материал хүлээн авч, үлдэгдэл 89.4 сая төгрөгийн материалыг хүлээн авалгүйгээр бараа материалын дансанд орлогоор бүртгэсэн.
- Говь-Алтай аймгийн ХХҮГ удирдлагын шийдвэргүй, өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэлээр 2020 оны 12 сард орлогод авсан үндсэн хөрөнгийн шинжтэй 8.4 сая төгрөгийн 6 ширхэг Samsung tab S6 lite таблет болон бусад нийт 9.1 сая төгрөгийн бараа материал акталсан;

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 44,205.0 сая төгрөг болж, өмнөх оноос 1,550.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	39,896,711.3	38,881,423.7	(1,015,287.60)
Барилга, байгууламж, орон сууц	36,591,199.2	36,900,303.5	309,104.25
Авто-тээврийн хэрэгсэл	2,948,380.3	2,936,716.9	(11,663.33)
Машин, тоног төхөөрөмж (компьютер)	11,030,289.1	10,665,061.8	(365,227.30)
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,014,256.9	4,164,296.6	150,039.68
Бусад үндсэн хөрөнгө	717,265.4	714,282.1	(2,983.33)
Ном	2,879.8	2,879.8	-
Биет бус хөрөнгө	5,859,313.6	5,323,660.6	535,653.03)
Программ хангамж	3,277,096.5	2,723,079.6	(554,016.95)
Бусад биет бус хөрөнгө	4,761,212.2	4,683,382.7	77,829.54)
Дүн	45,756,024.9	44,205,084.3	(1,550,940.62)

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн данс худалдан авалтаар 106.6 сая төгрөг, байгууллага хооронд болон бараа материалын данснаас шилжүүлэн бүртгэсэн 513.7 сая төгрөг, хандив тусламжаар 1,454.2 сая, Бусад 149.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, акталсан 2,303.5 сая төгрөг, шилжүүлсэн болон хоорондын тооцоогоор 633.1 сая, бусад 149.8 сая, худалдсан 48.4 сая төгрөг, 3,134.9 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр буурчээ.

Аудитын илрүүлэлт:

- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг цаашид ашиглах хугацаа болон шинэчлэн тогтоох үнийн саналаа боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлээгүй /Булган аймгийн ХХҮГ 74 ширхэг хөрөнгө, Дорноговь аймгийн ХХҮГ 121 ширхэг хөрөнгө, Сүхбаатар аймгийн ХХҮГ 146 ширхэг хөрөнгө, БГД-ийн ХХҮХ 87 ширхэг хөрөнгө/;
- Сүхбаатар аймгийн ХХҮГ 2.3 сая төгрөгийн үнэ бүхий автомашин дансанд бүртгэлтэй боловч биетээр оршин байхгүй, хөрөнгийг дээд шатны байгууллагад удаа хандсан боловч асуудал шийдэгдээгүй;
- Хан-Уул дүүргийн ХХҮХ нь 2021 оны жилийн эцэст 5.6 сая төгрөгийн элэгдлийн зардлыг нөхөж байгуулсан;
- ХХҮЕГ 379.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авахад ТӨБЗГ-н 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлээгүй;
- Налайх дүүргийн ХХҮХ ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 711 дүгээр тогтоолоор нээлттэй дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гарсан 7.9 сая төгрөгийн

дансны үнэтэй Ниссан Ринесса автомашиныг дуудлага худалдаа болохоос өмнө данс бүртгэлээс хассан;

- Сэлэнгэ аймгийн ХХҮГ тайлант онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийсэн 82.7 сая төгрөгийн өртөг бүхий их засварын ажлыг капиталжуулаагүй.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 19.7 сая төгрөг болж, өмнөх оноос 7.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	6,279.8	10,038.1	3,758.3
Байгууллагад төлөх өглөг	5,740.6	8,569.7	2,829.1
Хувь хүмүүст төлөх өглөг	612.3	1,138.8	526.5
Дүн	12,632.7	19,746.6	7,113.9

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд ХХҮЕГ-ын 7.5 сая, Булган аймгийн ХХҮГ-ын 4.8 сая, Налайх дүүргийн ХХҮХ-ийн 4.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл дийлэнх хувийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаагүйгээс 35.1 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. /Булган аймгийн ХХҮГ 4.9 сая, Дорнод аймгийн ХХҮГ хувь хүний орлогын албан татварын 30.2 сая/

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 46,748.5 сая төгрөг болж, өмнөх оноос 1,361.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	12,632.7	19,746.6	7,113.9
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,585,763.3	14,585,763.3	-
Өмнөх үеийн үр дүн	27,379,321.4	26,021,913.4	(1,357,408.0)
Тайлант үеийн үр дүн	6,132,028.6	6,121,144.5	(10,884.1)
Дүн	48,109,746.0	46,748,567.8	-1,361,178.2

Эх сурвалж: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,361.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг 32,737.4 сая төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналыг 3,136.0 сая төгрөгөөр бууруулж 29,601.4 сая төгрөгөөр баталсан байна.

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд зааснаар 605.6 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 541.8 сая төгрөг бүрдүүлснийг улсын төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 63.8 сая төгрөгөөр тасарсан нь Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд хилээр нэвтрэх орох, гарах хөдөлгөөнийг хаасантай холбоотойгоор хөдөлмөр эрхлэхээр ирэх гадаад иргэдийн тоо буурснаас шалтгаалсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны эхэнд төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээнд зориулан 29,224.5 сая төгрөгийн төсөв батлагдсан. 2021 онд төсөвт хасах тодотгол хийж 28,959.6 сая төгрөг буюу 264.9 сая төгрөгөөр бууруулж баталсан.

Нийт зарлагын 26,868.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 208.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 1,883.1 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 26,868.3 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож, зарцуулаагүй үлдэгдэл 541.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 117.4 сая төгрөгөөр бүрдүүлж, батлагдсан төсвөөс 90.7 сая төгрөгөөр тасарсан нь Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын улмаас хил хаагдаж, хөдөлмөр эрхлэх визээр орж ирэх гадаад иргэдийн тоо буурснаас үйлчилгээний шимтгэл, хураамжийн орлого дутуу бүрдэх гол шалтгаан болсон байна.

Туслах үйл ажиллагааны 1,883.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 417.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 1,466.0 сая төгрөгөөр тасарч, биелэлт 22.1 хувьтай байна. Орлогын төлөвлөгөө биелээгүй гол шалтгаан нь Ковид-19 цар тахалтай холбоотой ахмадын амралт сувиллын хэвийн үйл ажиллагаа алдагдсанаас шалтгаалжээ.

Төсвийн нийт зарлага цэвэр зээлийн дүн 26,860.7 сая төгрөг буюу 92.7 хувьтай байгаа нь баталсан орон тооноос 3 нэгжээр дутуу ажилласнаас цалин хөлс нэмэгдэл урамшил 111.1 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 70.8 сая, цар тахлын улмаас газар, хэлтсийн харьяанд үйл ажиллагаа явуулдаг ахмадын амралт, сувиллын үйл ажиллагааг зогсоосонтой холбоотой үндсэн үйл ажиллагаанаас санхүүждэг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 128.2 сая, мөн хангамж, бараа материалын зардал 96.3 сая, норматив зардал 545.3 сая, эд хогшил, урсгал засварын зардал 62.0 сая, томилолт, зочны зардал 7.9 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 986.3 сая, бараа үйлчилгээний бусад зардал 27.6 сая, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 63.1 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Цалин, урамшууллыг илүү тооцож, 2.3 сая төгрөг олгосон /Увс аймгийн ХХҮГ 1.1 сая, СХД-ийн ХХҮГ 0.7 сая, Нийслэлийн ХХҮГ 0.2 сая, Орхон аймгийн ХХҮГ 0.3 сая/;
- Япон улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 3 ажилтны цалингийн нэмэгдлээс 18.9 сая төгрөгийн НДШ болон ХХОАТ тооцоогүй;
- ХХҮЕГ нь БНСУ-д гарах ажиллах хүчний шалгалт зохион байгуулахтай холбогдсон зардлаас зориулалт бусаар урсгалд зардалд 14.9 сая төгрөгийг зарцуулсан;
- Говь-Алтай аймгийн ХХҮГ туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 55.0 сая төгрөгөөр тасалсан;
- Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ жилийн үр дүнгийн урамшууллыг сахилгын арга хэмжээтэй 2 албан хаагчид 0.4 сая төгрөг, 1 албан хаагчид тушаалд зааснаас илүү хувиар тооцож 0.3 сая төгрөг олгосон;

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 840.9 сая төгрөг, Засгийн газрын нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 680.7 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө 388.9 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 533.3 сая нийт 2,443.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил, үйлчилгээний зардалд 1,145.0 сая, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 11.1 сая, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж буюу хүүхдийн мөнгөнд 566.9 сая, хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх зардалд 258.8. сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 461.8 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлж, үүнээс 460.3 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталсан хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн зорилтын хүрээнд 8 арга хэмжээ баталснаас гүйцэтгэлээр 93.0 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг баталсан байна.

Хүснэгт-11 Хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2021 оны зорилтот түвшин	2021 оны хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
27.1	Нийгмийн халамж				
	27.1.1	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн олголтын хувь	96.0	98.0	102.0
	27.1.2	Зорилтот бүлэгт хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хамрагдалтын хувь	94.0	94.0	100.0
	27.1.3	Ахмад настнуудад насны хишиг олголтын хувь	96.0	100.0	102.0
	27.1.4	Цалинтай ээж хөтөлбөр болон 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж олголтын хувь	96.0	97.0	101.0
27.5	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих				
	27.5.1	Ажилгүйдлийн түвшин /хувиар/	9.5	8.1	85.2
	27.5.2	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин /хувиар/	56.6	53.6	94.7
	27.5.3	Шинээр бий болсон ажлын байрны тоо /мянган хүн/	30.0	28.4	94.7
	27.5.4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан иргэний тоо	5.6	3.9	69.7

Хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн гүйцэтгэл дунджаар 93.0 хувьтай байна.

3.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.8.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар нь орлогын 866.5 сая төгрөгийн 30 гүйлгээ, зарлагын 176.7 сая төгрөгийн 10 гүйлгээг байршуулах хуулийн хугацааг хоцроосон, Япон Улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь шилэн дансны мэдээллийн санд бүртгэлгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ 3.1. “Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1. “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” гэсэн заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газарт зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх, Япон Улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвд холбогдох байгууллагад хандаж шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах эрх үүсгэх зөвлөмж өгөх.

3.8.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Зөвлөмж

1.1 Илрүүлэлт:

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар өндөр насны тэтгэвэрт гарах үндэслэлээр ажлаас чөлөөлсөн 2 ажилтны орон тоонд нөхөн томилгоо хийсэн байна. Энэ нь “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол 1.2. “шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” гэж заасантай нийцээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, төсвийн хэмнэлттэй ажиллах бодлого баримтлах зөвлөмж өгөх.

2. 1Илрүүлэлт:

Ухаалаг засаглал төслөөс ХХҮЕГ-т 379.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлсэн ба хөрөнгө шилжүүлэх шийдвэрийг цаг хугацаандаа гаргаагүй, ашиглагч тал баримтыг бүрдүүлэх тал дээр ажиллаагүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 4.1 “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана” гэсэн заалттай нийцээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотой ТӨБЗГ-аас зохицуулсан эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллах зөвлөмж өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл, өндөр насны тэтгэвэрт гарах үндэслэлээр ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтны орон тоонд нөхөн томилгоо хийсэн, хөрөнгө шилжүүлэх шийдвэрийг цаг хугацаандаа гаргаагүй нь Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын холбогдох заалттай нийцээгүй байна гэж үзлээ.

3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 10.7 сая төгрөгийн 10 төлбөрийн акт, 718.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага, 610.2 сая төгрөгийн 56 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт.11 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	10	10.7	10	10.7	-	-	100.
Албан шаардлага	10	718.0	9	718.0	1	-	90.0
Зөвлөмж	56	610.2	54	610.2	2	-	96.4
Нийт дүн	76	1,338.9	73	1,338.9	3	-	53.2

3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын харьяа байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын явцад анхаарал татахуйц дараах асуудал байна. Үүнд:

- Улсын төсөвт төвлөрүүлэх болон туслах үйл ажиллагааны орлогын төвлөрүүлэлт;
- Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шинээр батлагдсан хууль тогтоомж, эрх зүйн актад орсон нэмэлт өөрчлөлт зэргийг тусган шинэчлэх;
- ХХҮЕГ-ын 67 ажилтны бүтэц, орон тоо батлагдсан ба 3 дэд дарга томилогдон ажиллаж байна;
- ХХҮЕГ-ын Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газраас ХЭДС-ийн 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагааг хяналт шалгалтад хамруулаагүй,
- Ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын суутгал зэргийг аудит хийх цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитад хамруулаагүй тул дараагийн аудитаар үргэлжлүүлэн үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,778.9 сая төгрөгийн 115 алдаа, зөрчил илэрснээс, 3,387.1 сая төгрөгийн 50 алдааг залруулж, 6.4 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 196.0 сая төгрөгийн 25 албан шаардлага хүргүүлж, 189.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 34 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил болох 391.8 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 334.8 сая төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас харьяа байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,778.9 сая төгрөгийн 115 алдаа, зөрчил илэрч, 3,387.1 сая төгрөгийн 50 зөрчлийг залруулж, 6.4 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 196.6 сая төгрөгийн 25 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 189.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 34 зөвлөмж өгсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-т “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 35 дугаар зүйлийн 35.2-т “Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 35 төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 32 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Аудитаар “Зөрчилгүй” 30, “Хязгаарлалттай” 2 дүгнэлт өгсөн байна. Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 3,778.9 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 3,387.1 сая төгрөгийн 50 зөрчлийг залруулж, 6.4 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 196.6 сая төгрөгийн 25 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 189.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 34 зөвлөмжийг хүргүүллээ.

Түүврийн байгууллага

Албан шаардлага

БНСУ-д ажиллах иргэдээс авах шалгалт зохион байгуулахтай холбогдон гарах зардлаас зориулалт бусаар урсгалд зардалд 14.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл. 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалттай нийцэхгүй ба “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар нь Нийгмийн халамжийн сангийн 2021 оны 11 дүгээр сард нийт 149.0 сая төгрөгийн брошур, плакат хийлгэх гэрээг Бит пресс ХХК-тай байгуулж, төлбөрийг тайлант онд 59.6 сая төгрөгийн материал хүлээн авч, үлдэгдэл 89.4 сая төгрөгийн материалыг хүлээн авалгүйгээр бараа материалын дансанд орлогоор бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: ... 5.1.4. үнэн зөв байх...”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх

Зөвлөмж

1.1 Илрүүлэлт

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын агуулахад хэрэглэх боломжгүй, ашиглалтгүй 6 нэр төрлийн 74.1 сая төгрөгийн гарын авлага, тараах материал оршин байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Хэрэгцээ шаардлага хангахгүй бараа материал бэлтгэхгүй байх зөвлөмж өгөх

2.1 Илрүүлэлт

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын авлага дансанд байгууллагаас авах 7.7 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, хувь хүнээс авах 0.2 сая төгрөгийн авлагыг баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Байгууллагаас авах 7.7 сая төгрөгийн авлагыг холбогдох байгууллагатай тооцоо нийлж шийдвэрлэх, хувь хүнээс авах 0.2 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил

/Мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн	Үүнээс									
			Үүнээс							Залруулсан		Акт		Албан шаардлага		Хариуцлаг а тооцох		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түүвэрт хамруулсан											
								Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний санхүүгийн газрын нэгтгэсэн тайлан	АХГ-2022/12/НА-СТА-ТТЗ	1		1				1									1	
2	Архангай аймгийн ХХҮГ	АРА-2022/24/НА-СТА-ТШЗ	1	1					-	-	-								
3	Баян-Өлгий аймгийн ХХҮГ	БӨА-2022/178/НА-СТА-ТШЗ	1	1					3	12,200.0	2	10,900.0			1	1,300.0			
4	Баянхонгор аймгийн ХХҮГ	БНА-2022/165/НА-СТА-ТШЗ	1	1					-										
5	Булган аймгийн ХХҮГ	БУА-2022/140/НА-СТА-ТШЗ	1	1					2	6,353.2	-	-						2	6,353.2
6	Говь-Алтай аймгийн ХХҮГ	ГАА-2022/58/-НА-СТА-ТШЗ	1	1					13	90,253.8	3	13,500.0			8	21,238.8			2
7	Говьсүмбэр аймгийн ХХҮГ	ГСА-2022/16/СТА-ТШЗ	1	1					-										
8	Дархан Уул аймгийн ХХҮГ	ДАА-2022/142/НА-СТА-ТШЗ	1	1					3	11,542.3	1	4,178.1			1	6,275.6			1
9	Дорноговь аймгийн ХХҮГ	ДГА-2022/166/НА-СТА-ТШЗ	1	1					7	187,400.0	3	183,400.0			1	4,000.0			3
10	Дорнод аймгийн ХХҮГ	ДОА-2022/159/НА/СТА-ТШЗ	1	1					2	800.0					1	500.0			1
11	Дундговь аймаг ХХҮГ	ДУА-2022/19/НА-СТА-ТШЗ	1					1	1	6,203.4	1	6,203.4							
12	Завхан аймгийн ХХҮГ	ЗАА-2022/207/СТА-ТШЗ	1	1					1	1,361.4								1	1,361.4

АХГ-2022/222/НА-СТА-ТТЗ

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

13	Орхон аймгийн ХХҮГ	ОРА-2022/22/НА-СТА-ТШЗ	1	1				7	17,041.0	2	12,961.8	2	406.9	1	1,455.0			2	2,217.3
14	Өвөрхангай аймгийн ХХҮГ	ӨВА-2021/32/НА-СТА-ТШЗ	1	1				2	4,570.0					2	4,570.0				
15	Өмнөговь аймгийн ХХҮГ	ӨМА-2022/116/НА-СА-ТШЗ	1	1				3	34,797.8	2	31,810.4							1	2,987.4
16	Сүхбаатар аймгийн ХХҮГ	СБА-2022/20/НА-СТА-ТШЗ	1	1				2										2	
17	Сэлэнгэ аймгийн ХХҮГ	СЭА-2022/249/-НА-СТА-ТШЗ	1	1				3	100,331.9	2	96,202.6							1	4,129.3
18	Төв аймгийн ХХҮГ	ТӨА-2022/03/-НА-СТА-ТШЗ	1	1				7	269,923.7	5	245,550.4			2	24,373.4				
19	Увс аймгийн ХХҮГ	УВА-2022/41/НА-СТА-ТШЗ	1		1			5	23,969.8	1	9,529.4	2	5,133.8	1	2,596.6			1	6,710.0
20	Ховд аймгийн ХХҮГ	ХОА-2022/21/НА-СТА-ТШЗ	1	1				2	6,936.7	2	6,936.7								
21	Хөвсгөл аймгийн ХХҮГ	ХӨА-2022/252/НА-СТА-ТШЗ	1	1				4	923.0	3	823.0							1	100.0
22	Хэнтий аймгийн ХХҮГ	ХЭА-2022/24/НА-СТА-ТШЗ	1	1				6	81,404.0	5	74,800.0			1	6,604.0				
23	БНСУ дахь ХНХҮТ	АХГ-2022/223/НА-СТА-ТШЗ	1	1				2	9,880.0					1	9,880.0			1	
24	Багануур дүүргийн ХХҮХ	ХАК-2022/276/НА-СА-ТШЗ	1	1				2	7,009.3	1	1,398.1							1	5,611.2
25	Багахангай дүүргийн ХХҮХ	ХАК-2022/85/НА-СА-ТШЗ	1	1				3	484.2	2	251.4							1	232.8
26	Баянгол дүүргийн ХХҮХ	ХАК-2022/278/НА-СА-ТШЗ	1	1				4	1,115.2					1	954.8			3	160.4
27	Налайх дүүргийн ХХҮХ	ХАК-2022/400/НА-СТА-ТШЗ	1	1				3	15,939.3	1	7,875.0							2	8,064.3
28	Нийслэлийн нийгмийн халамжийн газар	ХАК-2022/404/НА-СА-ТШЗ	1	1				6	223.8	4	758,372.0	1	161.9					1	61.9
29	Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ	ХАК-2022/281/НА-СА-ТШЗ	1	1				1	696.7			1	696.7						
30	Сүхбаатар дүүргийн ХХҮХ	ХАК-2022/277/НА-СА-ТШЗ	1	1				2	2,335.0	1	60.0			1	2,275.0				
31	Хан-Уул дүүргийн ХХҮХ	АХГ-2022/791/НА-СТА-ТШЗ	1	1				3	7,606.4					1	5,609.0			2	1,997.4
32	Чингэлтэй дүүргийн ХХҮХ	ХАК-2022/785/НА-СА-ТШЗ	1	1				-											
33	Баянзүрх дүүргийн ХХҮХэлтэс	ХАК-2022/22/НА-СА-ТШЗ	1	1				3	10,514.0									3	10,514.0
34	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар	АХГ-2022/227/НА-СА-ТТЗ	1				1	12	2,104,451.8	8	1,918,064.6			2	104,403.4			2	81,983.8
35	Япон дахь хөдөлмөр	АХГ-2022/227/НА-СА-ТТЗ	1				1	1	4,246.5	1	4,246.5								

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	нийгмийн хамгааллын үйлчилгээний төв																			
	Дүн		35	30	2	0	0	3	115	3,778,886.3	50	3,387,063.0	6	6,399.0	25	196,035.6	-	-	34	189,388.0

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	АХГ-2022/222/НА-СТА-ТШЗ	1	1,043.2							1	1,043.2		
2	Япон дахь хөдөлмөр нийгмийн халамж үйлчилгээний төв	АХГ-2022/224/НА-СТА-ТШЗ	1	-									1	-
3	Баян-Өлгий Аймаг ХХҮГ	БӨА-2022/178/НА-СТА-ТШЗ	1	-					1	-				
4	Дархан Уул аймгийн ХХҮГ	ДАА-2022/142/НА-СТА-ТШЗ	1	66,031.0					1	66,031.0				
5	Өмнөговь аймаг ХХҮГ	ӨМА-2022/116/НА-СА-ТШЗ	3	-					1				2	-
6	Хэнтий ХХҮГ	ХЭА-2022/24/НА-СТА-ТШЗ	2	69,900.0					2	69,900.0				
7	Увс аймгийн ХХҮГ	УВА-2022/41/НА-СТА-ТШЗ	1	175,465.4					1	175,465.4				
8	Баянгол дүүргийн ХХҮГ	ХАК-2022/278/НА-СА-ТШЗ	2	12,671.1					1	4,371.1			1	8,300.0
9	Багануур дүүргийн ХХҮХ	ХАК-2022/276/НА-СА-ТШЗ	1	962.4					1	962.4				
10	Багахангай дүүргийн ХХҮГ	ХАК-2022/85/НА-СА-ТШЗ	2	6,863.1					1	363.1			1	6,500.0
11	Налайх	ХАК-2022/400/НА-СТА-ТШЗ	1	1,265.7					1	1,265.7				
12	Сүхбаатар дүүргийн ХХҮХ	ХАК-2022/277/НА-СА-ТШЗ	1	332,052.8									1	332,052.8
13	Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ	ХАК-2022/281/НА-СА-ТШЗ	2	6,990.6					1	6,990.6			1	
14	Нийслэлийн нийгмийн халамжийн газар	ХАК-2022/404/НА-СА-ТШЗ	1	276,907.7					1	276,907.7				
15	Хан-Уул дүүргийн ХХҮХ	ХАК-2022/791/НА-СТА-ТШЗ	1	47,286.5									1	47,286.5
16	Чингэлтэй дүүргийн ХХҮХ	ХАК-2022/785/НА-СА-ТШЗ	1	1,106.0					1	1,106.0				
17	Баянзүрх дүүргийн ХХҮХ	ХАК-2022/22/НА-СА-ТШЗ	1	84,780.0					1	84,780.0				
	Дүн		23	1,083,325.5	-	-	-	-	14	688,143.0	1	1,043.2	8	394,139.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 759/А0160459

Улаанбаатар хот

АХГ-2022/202/НХ-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас харьяа байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,778,883,300.00 төгрөгийн 115 алдаа, зөрчил илэрч, 3,387,063,000.00 төгрөгийн 50 зөрчлийг залруулж, 6,399,000.00 төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 196,035,600.00 төгрөгийн 25 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 189,388,000.00 төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 34 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1 "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5 заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 14.2.2 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.5 "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 35 дугаар зүйлийн 35.2 "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа газруудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэн ажиллахад хяналт тавих, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэндаваа, Төсвийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн М.Мэндбаяр нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

\\10.10.10\\Bichig_Khereg\\Alban Shaardlaga\\2022\\0325 Auditin 2 Gazar-409.Docx

0001001342



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 458/А0160459

Улаанбаатар хот

АХГ-2022/222/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар нь Нийгмийн халамжийн сангийн 2021 оны 11 дүгээр сард нийт 149,039,100.00 төгрөгийн брошур, плакат хийлгэх гэрээг Бит пресс ХХК-тай байгуулж, төлбөрийг тайлант онд 59,615,640.00 төгрөгийн материал хүлээн авч, үлдэгдэл 89,423,460.00 төгрөгийн материалыг хүлээн авалгүйгээр бараа материалын дансанд орлогоор бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: ... 5.1.4 үнэн зөв байх...", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв тайлагнах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэндаваа, Төсвийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн М.Мэндбаяр нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0325 Auditin 2 Газар-4\2.Docx

0001081033



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 757/А0160459

Улаанбаатар хот

АХГ-2022/222/НА-СТА-Т13

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

БНСУ-д ажиллах иргэдээс авах шалгалт зохион байгуулахтай холбогдон гарах зардлаас зориулалт бусаар урсгалд зардалд 14,980,000.00 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,” гэсэн заалттай нийцэхгүй ба “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулахгүй байх, төсвийн хэмнэлттэй ажиллах бодлого баримтлах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэндаваа, Төсвийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн М.Мэндбаяр нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 769/А0160459

Улаанбаатар хот

АХТ-2022/202/НА - СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар нь орлогын 866,500,000.00 төгрөгийн 30 гүйлгээ, зарлагын 176,700,000.00 төгрөгийн 10 гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулах хуулийн хугацааг хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ 3.1 Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1 "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" гэсэн заалттай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2 1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг тухайд нь, иж бүрэн байршуулж байх албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэндаваа, Төсвийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн М.Мэндбаяр нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ

[illegible]